

ӨГҮҮЛЭЛ

Монгол-Хятадын хилийн Сүмбэр-Рашаан боомт: Өнөөгийн байдал, хөгжлийн боломж

Алтан*

Доктор Ph.D, ӨМИС-ийн Монгол Улсыг судлах хүрээлэн, Хөх хот, БНХАУ
alatan5330007@163.com

Дамдиндоржийн Базардорж

Доктор Ph.D, эрдэм шинжилгээний ажилтан,
ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс
bazardorjd@mas.ac.mn

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол-Хятадын хилийн Сүмбэр – Рашаан боомтын өнөөгийн байдал, хөгжлийн төлөв хандлага ба хоёр улсын төр засаг болон орон нутгаас баримталж буй хөгжлийн бодлогын уялдаа холбоо, түүнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын тухайд өгүүлэв. Чингэхдээ Сүмбэр – Рашаан боомт хэтийн таатай нөхцөлтэй байгааг дурдахын зэрэгцээ эдүгээх нөхцөл байдал нь хөгжлийн хүлээлтийн шатанд байгааг онцолж, тус боомтыг түшиглэсэн хоёр талын орон нутаг өөр өөрийн онцлогтой хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлж байгаа ч, харилцан уялдаж чадаагүйг тэмдэглэжээ. Хоёр талын орон нутгийн хөгжлийн уялдааг түргэтгэх ба Сүмбэр – Рашаан боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэхийн эхний алхам бол хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал чухал гэдгийг дурдав. Мөн Сүмбэр – Рашаан боомтоор түшиглэсэн хил дамнасан аялал жуулчлалыг байгуулах нь хоёр улсын харилцаанд энэ төрлийн хамтын ажиллагааны анхдагч болох ба чингэх нь Монгол – Хятадын хилийн бусад боомтуудаас ямар давуу тал хийгээд боломж нөхцөлтэй болохын тухайд дурджээ.

Зангилаа үгс: Сүмбэр – Рашаан, Монгол-Хятадын хилийн боомт, хил дамнасан аялал жуулчлал

* Холбоо барих зохиогч



Монгол Улс, БНХАУ хоёр 4709.6 км урт газраар хиллэдэг нь тус хоёр улсын аль алинд нь хөрш улсуудтайгаа хиллэх хамгийн урт хилийн шугам болохоос гадна АНУ-Канадын (8891 км), ОХУ-Казахстаны (7644 км), Чили-Аргентины (6691 км) хилийн шугамын дараа орох дэлхийн дөрөв дэх урт хоёр улсыг зааглах хуурай газрын хилийн шугам болдог. Өнөөгийн байдлаар Монгол, Хятад хоёр улс энэхүү урт хилийн шугамынхаа дагуу 12 газарт 13 боомт байгуулан харилцаж байна. Тэрхүү 13 боомтын нэг нь төмөр замынх (Замын-Үүд – Эрээний төмөр замын боомт), 12 нь авто замын боомтууд болохын нэг нь Сүмбэр (Монгол Улс) – Рашаан (БНХАУ) боомт юм. Сүмбэр – Рашаан боомт хоёр улсын хил дамнан оршин Халх – Нөмрөгийн сав газарт хилийн 1383 тоот багана орчимд Нөмрөгийн голоор зааглагдах ба тус хоёр улсын усан хил дээрх анхны бөгөөд цор ганц боомт юм. Хоёр улсын хилийн авто замын олон улсын зэрэглэлтэй дөрвөн боомтоос (Замын-Үүд – Эрээн, Бичигт – Зүүнхатавч, Булган – Такашкен,

Сүмбэр – Рашаан)-аас цор ганц түр горимтой, мөн хоёр улсын хамгийн сүүлд байгуулсан боомт юм.

Сүмбэр – Рашаан боомт Монгол Улсын талаас Дорнод аймгийн Халхгол сумын нутаг, БНХАУ-ын талаас ӨМӨЗО-ны Хянган аймгийн Рашаан хотын нутгийг зааглан оршино. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүнш 1135 км, БНХАУ-ын нийслэл Бээжин хотоос умарш 1370 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүнш 425 км, ӨМӨЗО-ны Хянган аймгийн төв Улаан хотоос баруун хойш 314 км, Халхгол сумын төвөөс зүүн урагш 85 км, Рашаан хотын төвөөс баруунш 45 км зайд байрлана. Газарзүйн энэхүү байрлал нь Монгол Улсын далайд гарах хамгийн дөт цэг тул далайд гарах болон Зүүн хойд Азийн интеграци дахь Монголын оролцоонд стратегийн чухал ач холбогдолтой үүд хаалга болдог бол БНХАУ-ын хувьд тус улсын зүүн хойд бүсийн баруун хаалга, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба аялал жуулчлалыг чухалчлан хөгжүүлж буй нутаг болно.

Нэг. Сүмбэр-Рашаан боомтыг хөгжүүлэх Монгол, Хятад хоёр улсын хөгжлийн стратеги ба бодлогын уялдаа

Монгол, Хятад хоёр улс 1990 оноос хойш бүх салбарт харилцаа хамтын ажиллагааг идэвхижүүлж, хоёр улсын харилцааны түвшинг нэмэгдүүлсээр ирсэн нь өнөөг болоход түүхэн хамгийн таатай цаг үедээ хүрээд байна. Хоёр улс 1994 онд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг шинэчлэн

байгуулж, улмаар Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцаа (2003), Стратегийн түншлэлийн харилцаа (2011), Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа (2014)-г байгуулж, харилцаа, хамтын ажиллагаа бүх салбарт хөгжүүлэх улс төрийн таатай орчныг нэгэнт бүрдүүлээд байна. Сүүлийн 30-аад

жилийн хугацаанд байнга дээшилсээр ирсэн хоёр улсын улс төрийн харилцааны түвшинг даган салбар салбарын харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй өрнөх болсоны үр дүнд 1992 онд Замын-Үүд – Эрээн боомт сэргэн нээгдэж, улмаар хилийн боомтууд дараалан байгуулагдсанаар хамгийн сүүлд буюу 2013 онд Сүмбэр – Рашаан боомт нээгдсэн байна.

Монгол Улсын хувьд уг боомтыг байгуулах болсон гадаад хүчин зүйл, гол шалтгаан нь БНХАУ, ОХУ-аар хүрээлэгдсэн газарзүйн хаагдмал байдлыг гэтлэн давах үүднээс тус хоёр хөршийг оролцуулсан Зүүн хойд Азийн бүс нутгийн улс орнуудтай харилцаа хамтын ажиллагааг эрчимжүүлэх шинэ суваг буй болгох, Түмэн гол санаачилгад идэвхийлэн оролцох асуудал болно. БНХАУ-ын хувьд хөрш улсуудтайгаа бүх талаар харилцаа, хамтын ажиллагааг идэвхижүүлэх, гадагш нээлттэй байх хөгжлийн стратегийн суурин дээр уг боомтыг БНХАУ-ын төрөөс “Хятадын Их Түмэн голын бүс нутгийн хамтын ажиллагааг эхлүүлэх төлөвлөгөө”-ны баруун хаалга хэмээсэн нь¹ Рашаан боомтыг нээх суурь болсон юм.

Ямартаа ч Сүмбэр – Рашаан боомт бол хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөх, чингэхдээ Зүүн хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх, түүн дэх хоёр улсын ашиг сонирхолыг

бодитжуулахад хандуулан байгуулагдсан байна.

Иймийн тул энэ бүс нутагт хилийн боомт нээх асуудал анх 2004 онд Монгол, Хятадын Засгийн газар хоорондын хэлэлцээрт тусгагдан², улмаар Сүмбэр – Рашаан боомтыг нээх эрх зүйн дотоод зохицуулалтаа хоёр тал идэвхийлэн боловсруулж эхэлжээ.

Монгол Улсын хувьд уг боомт нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хэтийн төлөв, олон улсын болон дотоодын бүх төрлийн замын сүлжээний уулзвар - гарц, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж, эдийн засгаа солонгоруулах шаардлага зэрэг хөгжлийн дотоод зорилтуудтай нь уялджээ. Улс орны дотоод, гадаадын хөгжлийн ийм шаардлагаас үүдэн Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 212 дугаар тогтоол гарсан нь Сүмбэр боомтыг байгуулах эрх зүйн суурь үндэс болжээ³. Улмаар 2005 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Монгол Улсын Засгийн газраас баталсан 202 дугаар тогтоолын Зүүн бүсийг хөгжүүлэх хөтөлбөрт Дорнод аймгийн Сүмбэр орчмоор аялал жуулчлалын шинэ боомт нээх, түүний дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, Хятад, Япон, Солонгос, Европын орнуудад сурталчлах замаар энэ бүс нутгийг олон улсын болон Зүүн хойд Азийн аялал жуулчлалын сүлжээнд

1 Рашаан хотын улс ардын эдийн засаг ба нийгмийн хөгжлийн XIII таван жилийн төлөвлөгөө. 阿爾山市国民经济和社会发展第十三个五年规划纲要 <http://www.xingandj.gov.cn/2016/0422/9558.shtml>

2 Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. 2004.07.05. Бээжин.

3 Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2002 №212.

хамруулах арга хэмжээ авах зэрэг асуудлыг тусгасан нь⁴ уг боомтын үйл ажиллагааны чиглэл болон тодорчээ.

Хожим 2010 онд батлагдсан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-оор Сүмбэр боомтыг төмөр замын чухал зангилаа болгохоор тусгасан⁵ ба Замын-Үүдийн төмөр замын боомтоос гадна хэтдээ буй болох Хятад руу гарах төмөр замын дөрвөн боомт (Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч, Сүмбэр-Рашаан)-ын нэг болгохоор тогтоол шийдвэрүүд батлагджээ.

Улмаар энэ бүс нутгийн нийгэм эдийн засгийн онцлог, хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан Сүмбэр-Рашаан хилийн боомтыг аялал жуулчлал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт импортоор дагнан хөгжүүлэх чиглэлд Монгол, Хятадын Засгийн газар санал нэгдэж, 2013 оны 7 дугаар сарын 14-ний өдөр боомтын үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлсэн юм. Чингэснээр Сүмбэр – Рашаан боомт Монгол, Хятадын хооронд хамгийн сүүлд байгуулсан хилийн боомт, чингэхдээ хоёр улсын хил дээр байгуулсан олон улсын чанартай тав дахь хилийн боомт болжээ.

2016 оны 6 дугаар сард байгуулагдсан “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөр бол уг хилийн

боомтын гүйцэтгэх үүрэг ач холбогдолыг хоёр улсын хэмжээнээс давуулж, бүс нутгийн хамтын ажиллагааны чухал нэгэн зангилаа газар болгосон байна. Монголын “Талын зам”, Хятадын “Нэг бүс, нэг зам”, Оросын “Евразийн холбоо” гэх гурван улсын хөгжлийн стратегиудийн уялдаанд байгуулагдсан тус хөтөлбөрт Сүмбэр – Рашаан боомт нь “Түмэн голын тээврийн коридор”, “Төмөр замын далайн эрэг 2 коридор” гэх зам тээврийн дэд бүтцийг байгуулах зангилаа газар, гарц болохоор тусгагдсан нь Сүмбэр – Рашаан боомт бүс нутгийн хамтын ажиллагаанд чухал үүд хаалгын үүрэгтэйгээр оролцох хэтийн төлөвийг нь улам тодотгосон байна⁶. Энэ нь уг боомтын Монгол Улсын нийгэм эдийн засгийн ба Зүүн хойд Хятадын хөгжлийн тойргуудын стратегийг хэрэгжүүлэх хийгээд улмаар Монгол-Хятадын Зүүн хойд Азийн харилцаанд гүйцэтгэх үүргийг улам тодорхой болгож, ач холбогдолыг нь өргөжин нэмэгдүүлж байна.

Ийнхүү хоёр улсын болон бүс нутгийн хөгжлийн стратегийн уялдаанд тус боомтын байршил нь төмөр замын болон автозамын чухал зангилаа цэг болж, голлон аялал жуулчлал, экологийн цэвэр бүтээгдэхүүн экспортолж, импортлох боомт болон хөгжүүлэхээр тусгагдсан байна.

4 Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2005 №202.

5 Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого. Монгол Улсын УИХ-ын тогтоол. 2010 №32, хавсралт.

6 Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр. Душанбе. 2016.

Хоёр. Сүмбэр – Рашаан боомтын өнөөгийн байдал

Хэдийгээр Сүмбэр – Рашаан боомтыг хөгжүүлэх хоёр улсын бодлого уялдаж, хөгжлийн стратеги тодорхой, хэтийн төлөв гэрэлтэй байгаа ч боомтын өнөөгийн үйл ажиллагаа анх байгуулагдсан 2013 оны үеийн гарааны шатнаас холдоогүй байна.

Доор хүснэгтэнд 2013-2019 оныг дуусталх хугацаанд буюу албан ёсоор үйл ажиллагаагаа нээснээс хойш “Ковид-19” цар тахал дэгдэх цаг хүртэл Сүмбэр – Рашаан боомтоор нэвтэрсэн зорчигчдын болон тээврийн хэрэгслийн тоог үзүүлэв.⁷

Эндээс бид Сүмбэр – Рашаан боомтын хил нэвтрүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөв зургийг харж болох ба энэхүү үзүүлэлт нь тус боомт хөл хөдөлгөөн хэт багатайг илтгэнэ.

Монгол, Хятадын хилийн боомтуудаар дамжин өнгөрсөн зорчигчдын тоон үзүүлэлтээр бол Сүмбэр – Рашаан боомт хоёр улсын хил дээр байгуулагдсан бүх авто замын 12 боомтоос 11 дүгээрт орох бага үзүүлэлттэй байна. Хоёр улсын

хил дээрх олон улсын зэрэглэлтэй авто замын дөрвөн боомтын нэг болохын хувьд ижил статустай нөгөө гурван боомттой харьцуулахын аргагүй дүр зураг харагдана. Тухайлбал, Сүмбэр – Рашаан боомтоор хамгийн олон зорчигч бүртгэгдсэн жил буюу 2019 оны үзүүлэлтийг суурь болгоход тус жил тус боомтоор зорчигчдын тоо Замын-Үүд – Эрээний авто замын боомтоор (2 279 835) зорчигчдоос 765 дахин бага, Бичигт – Зүүнхатавч боомтоор (99 359) зорчигчдын тооноос 33 дахин бага, Булган – Такашикэн боомтоор (70 407) зорчигчдын тооноос даруй 23 дахин бага байна. Мөн 2019 онд Сүмбэр – Рашаан боомтоор дамжин хоёр улсын хооронд 474 мянган ам.долларын худалдаа хийгдсэн нь⁸ тухайн жилийн гүйцэтгэлээр 8.8 тэрбумаар ам.доллараар хэмжигдсэн хоёр орны худалдаанд⁹ өчүүхэн үзүүлэлт юм.

Сүмбэр – Рашаан боомт улирлын чанартай ажилладаг учраас ижил статустай дээрх байнгын үйл ажиллагаатай боомтуудтай харьцуулах

Сүмбэр - Рашаан боомтоор нэвтэрсэн зорчигч болон тээврийн хэрэгслийн тоо⁷

Сүмбэр	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Зорчигч, Давхардсан тоогоор	704	1602	1885	1156	2365	2979	2978
Тээврийн хэрэгсэл, Давхардсан тоогоор	154	333	517	342	821	1173	1378

7 Монгол Улсын Үндэсний статистикийн газрын цахим хуудас.www.1212.mn

8 阿尔山市2020年政府工作报告 Рашаан хотын 2020 оны Засгийн газрын ажлын тайлан. http://www.aes.gov.cn/aes/zwgk39/cyzw_59/zfbg1/3323763/index.html

9 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Гадаад худалдаа – 2019 он. УБ., 2020. 10-р тал

оновчгүй байж болох ч, улирлын чанартай ажилладаг бусад боомтуудтай бас жишиг үл болох юм. Учир нь Сүмбэр – Рашаан боомт Монгол, Хятадын хилийн улирлын чанартай ажилладаг боомтуудаас хамгийн урт хугацаанд нээлттэй байдаг боомт болно. Тодруулбал, Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай 2004 оны хэлэлцээр болон 2016 онд дипломат шугамаар тохиролцсон боомтын ажиллах хуваариар тус боомт жил бүрийн 6 дугаар сарын 11-30, 7 дугаар сарын 16-30, 8 дугаар сарын 16-наас 9 дүгээр сарын 25-ныг дуустал буюу жилд 41 хоног ажилладаг байсныг 2017 онд 6-8 дугаар сард бүтэн, 9 дүгээр сард 1-25-ны өдөр буюу жилд 117 хоног ажиллуулахаар сунгажээ. Улмаар 2018 оноос жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 30 хүртэл ажилладаг болсон нь жилд 240 өдөр буюу өвлөөс бусад улиралд ажиллахаар зохицуулагдаж байна.

Ажиллах цагийн хуваарь богино хугацаанд ийнхүү хэдэнтээ өөрчлөгдөн, ажиллах өдрийн тоо тогтмол нэмэгдсээр байгаа нь хоёр талаас Сүмбэр – Рашаан боомтыг чухалчлан үзэж байгаатай юуны өмнө холбоотой. Гэтэл хил нэвтрүүлэх ажиллагаанд тогтвортой өсөлт гарсангүй ба өсөлт гарах төлөв харагдахгүй байна. Хамгийн ихээр зорчигч нэвтрүүлсэн 2018, 2019 оны зорчигчдын нийт тоо

(2018 онд 2979, 2019 онд 2978)-г тухайн онуудад боомтын ажилласан өдөр (240)-ийн тоонд хуваан дундажлан үзвэл өдөрт ердөө л 12 хүн уг боомтоор орж, гарсан байна.

Хятадын талын Рашаан боомтын нэвтрүүлэх хүчин чадал Сүмбэр боомтынхоос хавьгүй сайн тул Сүмбэр – Рашаан боомтын нэвтрүүлэх хүчин чадал Монголын талын Сүмбэр боомтын хүчин чадлын хэмжээгээр хязгаарлагдана. Монголын талын Сүмбэр боомт өдөрт 50-80 авто тээврийн хэрэгсэл, 100-250 зорчигч улсын хилээр нэвтрүүлэх хүчин чадалтай¹⁰. Эдгээрээс харвал, өдөрт дунджаар 12 хүн нэвтрүүлж байгаа нь тун чамлалттай ба Сүмбэр боомтын тодорхойлогдсон хүчин чадлын 5 хувийг ч ашиглаж чадахгүй байгаа юм.

Сүүлийн жилүүдэд Монгол, Хятад хоёр улсын харилцаа эрчимжиж, үүнийг дагалдан хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал олонтоо сөхөгдөх боллоо. Харин Сүмбэр – Рашаан боомтын тухайд боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг ярих биш, одоогийн байгаа хүчин чадлыг хэрхэн бүрэн дүүрэн ашиглах тухайд онцолж ярих шаардлагатай. Чингэхийн тулд Сүмбэр боомтын тодорхойлогдсон хүчин чадлыг бүрэн ашиглах хүртэл нэвтрэх зорчигчдын тоог багадаа 20 дахин нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

10 Монгол Улсын Хил хамгаалах Ерөнхий газрын сайт. <http://bpo.gov.mn/content/55> үзсэн 2021.03.15

Гурав. Боомтын орон нутгийн хөгжлийн тухайд

Сүмбэр боомт ба Халхгол сум. 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын УИХ-ын тогтоолоор “Хилийн боомтын тухай” хуулийг хүчингүй болгож, “Монгол Улсын хилийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгийг баталснаар уг хууль 2017 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн билээ. Хууль ёсоор Сүмбэр боомтод боомтын үйл ажиллагааг гааль, хил, мэргэжлийн хяналтын байгууллагууд хамтран хангаж байна¹¹. Сүмбэр боомт Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлөөс болон хүн амын төвлөрлөөс алслагдсан, зам тээврийн дэд бүтэцгүй, боомт ашиглалтын эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус зэрэг шалтгаанаас хүчин чадлаараа ажиллах боломж бүрдээгүй.

Сүмбэр боомт байрлах Дорнод аймгийн Халхгол сум 3500 орчим хүн амтай, газар нутгийн хувьд Монгол Улсын хамгийн том суманд тооцогдоно. Халхгол сумын нутагт Нөмрөгийн дархан цаазат газар, Халхголын түүх соёлын болон байгалийн дурсгалт газар, хөдөө аж ахуйн чөлөөт бүсийн нутаг дэвсгэр байдаг. Халх Нөмрөгийн сав газар нь байгалийн олон янз тогтоцтой, Хянганы экосистем, Манжуурын гаралтай ан амьтан, дэлхийд ховордсон биологийн төрөл

зүйл бүхий үзэсгэлэнт сайхан нутаг. Тус бүс нутагт Хянганы нурууны ойт хээрээс Дорнод Монголын хээр талд шилжих байгалийн завсрын онцлогийг онгон төрхөөр нь үзэж танилцах боломжтой Монголын цорын ганц нутаг тул аялал жуулчлалыг хөгжүүлэх арвин баялаг нөөцтэй юм.

Монгол Улсын төр засгаас аялал жуулчлалыг хөгжүүлэх явдлыг чухалчлан үзэхдээ Халхгол, Буйр нуур, хил орчмын аялал жуулчлалыг дэмжих чиглэлийг нэгэнт тогтоосон¹² тус сумын төвд томоохон бүтээн байгуулалтын ажлыг хийжээ¹³. Мөн Монгол Улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх гол чиглэлд Сүмбэр боомтыг багтаасан Халхгол орчмын нутаг хамрагдсан байна¹⁴. Дорнод аймгийн хэмжээнд ч аялал жуулчлалыг хөгжүүлэх гол чиглэлд Халхгол орчмын бүс нутаг онцгой байр эзэлж байна¹⁵. Иймээс Монгол Улсын төр засгийн бодлогийн түвшинд ч, аймаг, сум орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт ч Халхгол сумын хөгжлийн чухал нэгэн чиглэл нь аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал юм. Сүүлийн жилүүдэд дотоодын жуулчид тус бүс нутагт аялалаар ирэх нь илэрхий нэмэгдэв.

Халхгол сумын нутагт Сүмбэр боомтоос гадна БНХАУ-тай залгах

11 Монгол Улсын хилийн тухай хууль. Шинэчилсэн найруулга. УИХ-ын тогтоол. 2016. Улаанбаатар

12 Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөр “Алсын хараа 2050”. УИХ-ын тогтоол. 2020.05.13.№52

13 Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын сайт: <https://president.mn/15613/> үзсэн 2021. 03.15.

14 Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай Засгийн газрын 2018 оны 171 дүгээр тогтоол.

15 Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө батлах тухай. Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 7 дугаар хурлын тогтоол. 2018.03.23.№08

хоёр талын зэрэглэлтэй байнгийн ажиллагаатай авто замын Баянхошуу – Өвдөг боомт буй. Хэдийгээр аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай нөхцөл бүхий байгал, түүх-соёлын арвин их нөөцтэй, хөдөө аж ахуйн үржил шимт уудам дэлгэр эдэлбэр нутагтай, орон нутгийн онцлогтой хөдөө аж ахуйн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн асар их нөөцтэй, хилийн хоёр боомттой боловч Халхгол сумын нийгэм эдийн засгийн хөгжил буурай.

Рашаан боомт ба Рашаан хот. БНХАУ-ын боомтын удирдлагын тогтолцооны хувьд Манжуур боомтод харьяалагдах хилийн хоёрдугаар түвшний боомт юм. Боомт нь хэдийгээр байгуулалтын хувьд тус улсын стандартад хангалттай үнэлэгдэж чаддаггүй ч Рашаан хот нь аялал жуулчлалыг сайтар хөгжүүлжээ. Хятадын талаас Эрээн хотын дараа эрэмблэгдэх Монгол, Хятадын хилийн хоёр дахь том боомтын хот юм. Эрээн хотоос ялгаатай нь анхнаасаа боомт дагаж хөгжөөгүй ба хожим хилийн боомт хот болжээ. Хотын өнгө төрх Европ маягтай, 68 мянган хүнтэй, төмөр замтай, зам тээврийн дэд бүтэц бүрэн хүрэлцээтэй. Бээжин Хөх хот зэрэг Хятадын дотоодын нислэгийн шугамтайгаас гадна Улаанбаатар хотын чиглэлд туршилтын нислэгийг үе үе үйлддэг. Энэ суурин дээр Рашаан – Чойбалсан – Улаанбаатар, Рашаан – Эрхүү – Улаан-Үд, Рашаан – Сөүл – Чэжү арал гэх агаарын нислэгийг

буй болгох талаар гадаад хамтын ажиллагааг идэвхитэй өрнүүлж байна. 2019 оны байдлаар Монгол Улсын Өвөрхангай аймаг, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Чойбалсан хотуудтай хамтын ажиллагааны гэрээтэй байна¹⁶.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх байгалийн өгөгдөл ихтэй давуу байдлаа ашиглан аялал жуулчлалыг хурдацтайгаар хөгжүүлж байна. Нутаг дэвсгэрийн 80% илүү нь ойн бүрхэвчтэй, БНХАУ-ын онц чухал байгалийн үзэмж төгс газар юм. Хятадын дотоодод аялал жуулчлалын гол газруудаар хүрээлэгдсэн ба аялал жуулчлалын 25 том коридорын нэг, Өвөр Монголын аялал жуулчлалын алтан бүс болох стратеги зорилтой¹⁷. Тус хот “Хятадын аялал жуулчлалын шилдэг хот”, “Бүх Хятадын байгалийн аялал жуулчлалын үлгэр жишээ бүс”, “Нэг бүс, нэг замын эрүүл аялал жуулчлалын зорилтот газар”, “Хятадын гадаад жуулчдын сонирхолыг ихээр татдаг 50 газрын нэг”-ээр тодорчээ¹⁸.

Рашаан хотод ирэх жуулчдын тоо тогтмол өссөөр 2019 онд 4 сая 986 мянгад хүрч, аялал жуулчлалын салбараас ихээр орлого олж байна. Рашаан хотод ирдэг жуулчдын аяллын хөтөлбөрт улсын хилийг сонирхох аялал чухал байр суурьтай байх ба зөвхөн 2019 онд хилийн боомт болон түүний ойр орчмыг үзэхээр зориуд зорин ирсэн жуулчдын тоо 70 мянгийг

16 阿爾山市2020年政府工作報告 Рашаан хотын 2020 оны Засгийн газрын ажлын тайлан. http://www.aes.gov.cn/aes/zwgk39/cyzw_59/zfbg1/3323763/index.html

17 Рашаан хотын улс ардын эдийн засаг ба нийгмийн хөгжлийн XIII таван жилийн төлөвлөгөө. 阿爾山市国民经济和社会发展第十三个五年规划纲要 <http://www.xingandj.gov.cn/2016/0422/9558.shtml>

18 Рашаан хотын Ардын засгийн ордны сайт. 阿爾山市人民政府網 <http://www.xam.gov.cn/aes/zjaes/lsw26/1334344/index.html>

давжээ.¹⁹ Монголын хил орчимд аялал жуулчлалыг ийнхүү онцгойлон эрчимтэйгээр хөгжүүлж байгаа хот, нутаг одоогоор БНХАУ-д өөр үгүй.

Дээр бид Сүмбэр – Рашаан боомтын хоёр талын орон нутгийн хөгжилд эко бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тэр тусмаа аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэл чухал суурьтай болохыг харав. Халхгол сум ба Рашаан хот нь өөр өөрсдийн улсын иргэдэд

түшиглэн дотооддоо хил орчмын аялал жуулчлалыг хоёр талд адил бус түвшинд, салангид байдлаар хөгжүүлж байгаа ба хамтын ажиллагааны уялдаа холбоо биежээгүй ажээ. Үүний хамгийн чухал шалтгаан нь Сүмбэр – Рашаан боомтоор жуулчид нэвтрэх (ялангуяа Хятад жуулчдаас виз шаарддаг) хууль эрх зүйн орчин аялал жуулчлалыг хөгжүүлэхэд таатай бус байгаатай холбоотой юм.

Дөрөв. Хил дамнан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж

Улам бүр өргөжин тэлж, эрчимжин өрнөж буй Монгол, Хятадын хоёр талын харилцаанд зайлшгүй анхаарч ахиулах ёстой хамтын ажиллагааны чиглэл бол хил дамнан аялал жуулчлалыг зүй зохистойгоор хөгжүүлэх явдал бөгөөд үүний тэргүүн эгнээнд Сүмбэр – Рашаан боомтын үйл ажиллагаа хамаарна.¹⁹

Өнөөгийн байдлаар, Сүмбэр – Рашаан боомтын хоёр талын орон нутгийн аялал жуулчлалын хөгжлийн байдал нь дотоодын хил орчмын аялал жуулчлалд тулгуурлаж байгаа ба энэ нь хил дамнан аялал жуулчлалын бэлтгэл байдалтай байна. Иймээс хоёр талын хөгжлийг уялдуулах чухал нэгэн чиглэл нь хил дамнан аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал бөгөөд энэ нь Сүмбэр – Рашаан боомтын үйл ажиллагааг сэргээх анхны алхмын гол хамтын ажиллагаа болох юм.

Одоогоор Монгол Улсад хөрш улсуудтайгаа хамтран хил дамнан аялал жуулчлалын бүс байгуулсан

туршлага байхгүй. Хэдийгээр Монгол Улсын голлох үзэл баримтлал, хөгжлийн зорилтуудад аялал жуулчлалыг чухалчлан үзсээр ирсэн ч хил дамнан аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал бодлогын баримт бичгүүдэд хожуу тусгагджээ. Тухайлбал, 2015 оны Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор анх удаа хил дамнан аялал жуулчлалыг хөрш орнуудтай хамтран байгуулахыг дэмжинэ, 2025 он гэхэд хил дамнан аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн замналыг буй болгосон байна²⁰ хэмээн зорилт болгожээ. Улмаар 2018 онд мөн Засгийн газрын тогтоолоор хил орчмын болон хил дамнан аялал жуулчлалын чиглэлийг баталж²¹, түүнд Хятадтай залгах хилийн шугамын дагуух боомт бүхий 13 газрын 12-т нь хил орчмын болон хил дамнан аялалын чиглэлийг гаргасан ч бүхэлдээ хил орчмын аялал жуулчлалын чиглэлийг баталж, хил дамнан аялал жуулчлалыг хөгжүүлэх тухайд тодорхой тусгаагүй орхисон

19 Рашаан хотын 2020 оны Засгийн газрын ажлын тайлан. 阿爾山市2020年政府工作报告 http://www.aes.gov.cn/aes/zwgk39/cyzw_59/zfbg1/3323763/index.html

20 Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2025. Засгийн газрын тогтоол. 2015 №324.

21 Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай Засгийн газрын тогтоол. 2018 №171, Хавсралт II.

байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс дахь хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт нь уг зорилтын эхний шат болох хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх түвшинд хэрэгжиж байгаа хэмээн үзэж болох байна.

Харин БНХАУ улс орныхоо эдийн засагт үйлчилгээний салбар голлосон бүтцийн өөрчлөлт хийхдээ аялал жуулчлалыг онцгойлон хөгжүүлэх бодлого барьсны нэг чиглэл нь хил дамнасан аялал жуулчлал болж, сүүлийн жилүүдэд богино хугацаанд эрчимтэй хөгжиж байна. Анх Түмэн гол санаачлагын хүрээнд Орос, Умард Солонгостой хамтран гурван улсын хил дамнасан аялал жуулчлалын бүс байгуулах санаачлага дэвшүүлж байсан нь “Нэг бүс, нэг зам”-аар дамжин улам өргөжиж, хоёр талт хил дамнасан аялал жуулчлалын бүс байгуулах чиглэлд эрчимжиж байна. Ийм чиглэлээр Орос, Вьетнамтай тус бүр гурван газарт, Мьянмар, Лаос, Монгол (Рашаан-Сүмбэр боомт)-той тус бүр нэг газарт хөгжүүлэхийг онцолжээ. Өөрөөр хэлбэл, Сүмбэр – Рашаан боомтыг хил дамнасан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх асуудал БНХАУ-ын хувьд хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх анхдагч газруудын нэгэн болж байгаа юм. Тус улсын Төрийн зөвлөл 2015 оны 12 дугаар сард хил дагуух муж, Өөртөө Засах орнуудын 11 хилийн хотод хил дамнасан аялал жуулчлалын бүс байгуулах шийдвэрийг гаргасанд Рашаан хот багтсан юм²².

Хил дамнасан аялал жуулчлалын

бүс нь Хятадаас хөрш орнуудад жуулчлах гол чиглэл болон хөгжих төлөвтэй байна. Хилийн дагуух боомт бүхий газруудаа түшиглэн дотоодын аялал жуулчлалын урсгалаа хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд мөн чиглүүлсэн ба энэ нь хил дамнасан аялал жуулчлалын бүсийг харахан байгуулж завдаагүй Монгол зэрэг хөрш орнуудтай хожим байгуулах хил дамнасан аялал жуулчлалын бүс болох бэлтгэл болон хангагдаж байна.

БНХАУ Монгол Улстай залгах хилийн боомтуудад түшиглэн хил орчмын аялал жуулчлалыг хэрэгжүүлсэн ба дараагийн шатанд боомт бүхий орон нутгийн хил орчмын аялал жуулчлалаа хил дамнасан аялал жуулчлалын бүсийн хэмжээнд хөгжүүлэх сонирхолтой байна. Тиймээс боломж бүрдвэл Монголтой хаяалах бүх боомтыг түшиглэн жуулчдын урсгалыг нээх эрмэлзэлтэй ба төрийн бодлого нь ч үүнд нээлттэй буй. Чингэхдээ хил дамнасан аялал жуулчлалыг эхний ээлжинд хоёр улсын болон бүс нутгийн хэмжээнд боомтуудын нөхцөл байдал ач холбогдолыг нь эрэмбэлж Рашаан боомтыг ингэж хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажээ.

Дээрх байдлаас бид хоёр улсын хооронд хил дамнасан аялал жуулчлалыг хамтран хөгжүүлэх асуудал нь Монгол талын аялал жуулчлалын салбарын хүрсэн түвшин хийгээд шийдвэр гаргагчдын санал санаачлагаас шууд шалтгаалж буй ба Хятадын тал хүлээлтийн байдалд байгааг харж болох юм.

22 Хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх тухай БНХАУ-ын Төрийн зөвлөлийн бодлогын арга хэмжээний санал. 2015.12.24

Иймээс Монголын талаас улс орныхоо нөхцөл байдалд уялдуулж, нөхцөл бүрдсэн тодорхой нэг боомтыг сонгон авч, хил дамнасан аялал жуулчлалыг БНХАУ-тай хамтран хэрэгжүүлэх санаачилгийг дэвшүүлж, идэвхитэй ажиллах шаардлага тулжээ. Монголын хөгжлийн онцлогт нийцүүлэн, хэтийн бүс нутгийн хамтын ажиллагаанд уялдуулахыг алсын хараа болгож Монгол, Хятадын хил дамнасан аялал жуулчлалын бүсийг тодорхой хугацаанд эхний ээлжинд туршилтын журмаар хэрэгжүүлэх санаачлага дэвшүүлж, Хятадын талтай хамтрах нь оновчтой билээ. Чухам ингэж хөгжүүлэх нөхцөл бүрдсэн газар бол Сүмбэр – Рашаан боомтыг түшиглэсэн

Халх голын сав нутаг билээ.

Чингэснээр Сүмбэр-Рашаан боомтыг хөгжүүлэх хоёр улсын стратеги уялдааг бодитжуулах анхдагч бодитой алхам болох юм. Улмаар Хятад, Оросын хилийн Манжуур-Забайкальский хил дамнасан аялал жуулчлалын бүстэй уялдуулж, аажимдаа Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридор байгуулалтыг урагшлуулах, дараагийн алхамд бүс нутгийн хэмжээнд өргөтгөх боломжоор хангагдаж, Зүүн хойд Азийн бүс нутаг, Түмэн голын хамтын ажиллагаанд хоёр талын оролцоог бодит нөхцөлөөр хангах урьдач нөхцөл болох юм.

Дүгнэлт

Сүмбэр – Рашаан боомтыг хөгжүүлэхийг Монгол, Хятад хоёр улс аль аль нь чухалчлан үзсээр байгаа тул урт хугацааны хөгжлийн бодлогын уялдаа сайтай байна. Гэсэн ч Сүмбэр – Рашаан боомтын ашиглалт өнөөгийн байдлаар хангалтгүй, хөгжлийн анхны түвшингээсээ ахихгүй байгаа бөгөөд үүний шалтгаан нь нэгдүгээрт, хэтийн бүтээн байгуулалт ба хөгжлийн хүлээлтийн байдалд байгаатай, хоёрдугаарт, боомтын хоёр талын орон нутаг хооронд худалдаа,

бизнесийн болон нийгэм эдийн засгийн харилцааны урьдач нөхцөл бүрдээгүй байгаатай холбоотой. Тиймээс энэхүү хоёр шалтгааныг чухалчлан харж, Сүмбэр – Рашаан боомтын үйл ажиллагааг эхний удаад эрчимжүүлж, тус боомтыг түшиглэсэн стратегийн хамтын ажиллагааны чиглэлүүдийг алхам алхамаар бодитжуулахад суурь болж чадах хамтын ажиллагааны анхдагч чиглэл бол хил дамнасан аялал жуулчлалыг өрнүүлэх асуудал болж байна.

Ашигласан материал:

1. Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө батлах тухай. Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 7 дугаар хурлын тогтоол. 2018 №08
2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2025. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2015 №324
3. Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2018 №171
4. Гадаад худалдаа – 2019 он. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. УБ., 2020.
5. Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2005 №202.
6. Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. 2004. Бээжин.
7. Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр. 2016 Душанбе.
8. Монгол Улсын Үндэсний статистикийн газрын цахим хуудас www.1212.mn
9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудас. <https://president.mn>
10. Монгол Улсын Хил хамгаалах Ерөнхий газрын цахим хуудас. <http://bpo.gov.mn/>
11. “Монгол Улсын хилийн тухай хууль”. Шинэчилсэн найруулга. 2016.
12. Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөр “Алсын хараа 2050”. УИХ-ын тогтоол. 2020 №52
13. Рашаан хотын улс ардын эдийн засаг, нийгмийн хөгжлийн XIII таван жилийн төлөвлөгөө. 阿尔山市国民经济和社会发展第十三个五年规划纲要 <http://www.xingandj.gov.cn>
14. Рашаан хотын 2020 оны Засгийн газрын ажлын тайлан. 阿尔山市2020年政府工作报告 <http://www.aes.gov.cn>
15. Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого. УИХ-ын тогтоол. 2010 №32
16. Хилийн боомтуудын талаар баримтлах үйл ажиллагааны чиглэл батлах тухай. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2002 №212.
17. Хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх тухай БНХАУ-ын Төрийн зөвлөлийн бодлогын арга хэмжээний санал. 2015.12.24

Sumber-Rashaan port on the Mongolian-Chinese border: Current situation and development opportunities

*Alatan Nasanbayar**

*Ph.D, Researcher, Mongolian Research Institute,
Inner Mongolia University, Hohhot, China
alatan5330007@163.com*

Bazardorj Damdindorj

*Ph.D, Institute of International Affairs,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia
bazardorjd@mas.ac.mn*

Abstract: *This paper studies the current state and the development prospects of the Sumber-Rashaan port on the Mongolian-Chinese border, and analyzes the alignment between the central and local governments policies of the two countries', and the problems faced in implementing the alignment. The paper argues that the Sumber-Rashaan port has highly favorable conditions and it is yet to be developed further. Although the border regions of the two countries are developing distinct tourism, they have not achieved mutual alignment yet.*

This paper argues that the first step to align local development between the two countries and strengthen the Sumber-Rashaan port activities, is to develop cross-border tourism. Further, the paper argues that the establishment of cross-border tourism based on the Sumber-Rashaan port will be the first of its kind in the bilateral relations, and through this precedent to demonstrate advantages and possibilities of cross-border tourism to other ports on the Mongolian-Chinese border.

Keywords: *Sumber - Rashaan, Mongolian-Chinese border port, cross-border tourism*

<i>The day of submission:</i>	<i>2021.04.26</i>
<i>Completion of review:</i>	<i>2021.05.15</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2021.06.09</i>

* Corresponding author